

**СОНИРХЛОО ИЛЭРХИЙЛЭХ ХҮСЭЛТ**  
(ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ – ХУУЛИЙН ЭТГЭЭД)

**Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэн Монголын Олборлох салбарын ил тод байдлыг бэхжүүлэх төсөл**

Зээл/Хөнгөлөлттэй зээл/Буцалтгүй тусламжийн дугаар: TF0B8169

Даалгаврын нэр: **PR, харилцаа холбоо, мэдээллийн чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх**

**Худалдан авалтын төлөвлөгөөний харгалзах дугаар: CS-C 1.1-1**

Монголын ОУИТБС нь Дэлхийн банкны “ОУИТБС-ыг хэрэгжүүлэн Олборлох салбарын ил тод байдлыг бэхжүүлэх” сангаас санхүүжилт хүлээн авч, зөвлөх үйлчилгээний үйл ажиллагаанд зарцуулна.

Дурдсан зөвлөх үйлчилгээг ОУИТБС-ын талаарх иргэд, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, иргэдийг мэдээллээр хангахтай холбоотой дараах үйл ажиллагааг багтаана.

1. Холбогдох 4 аймагт хэвлэл мэдээллийн бүтээлч ажлын тухай сургалт зохион байгуулах;
2. Ирүүлсэн бүтээлүүдээс шилдэгийг нь шалгаруулах үйл ажиллагаа зохион байгуулах;
3. Шалгарсан шилдэг бүтээлийг олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулах;
4. Улаанбаатар хотод сургалт зохион байгуулах;

Хэрэгжүүлэх нийт хугацааг 3 сараас хэтрүүлэхгүй байх бөгөөд 2023 оны 10-р сард эхлүүлэхээр төлөвлөж байна.

ДБХАД-ын 7.2-д заасны дагуу үндсэн үйл ажиллагаа, ажилласан жил, холбогдох туршлага, компанийн мэргэжил болон удирдлагын чадавхыг (Ажлын даалгаварт заасан ерөнхий шаардлагууд) үндэслэн энэхүү даалгаварт ажлыг хэрэгжүүлэх чадвартай эсэхийг үнэлнэ. Үндсэн ажилчдыг үнэлэхгүй. Хууль ёсны эсэх, сонирхлын зөрчилтэй эсэхийг мөн үнэлнэ. (ДБХАД-ийн 3.21-23 Хууль ёсны байдал).

Компанийн ур чадварын үнэлгээнд түүний салбар, толгой компани, хувьцаа эзэмшигч, дэд гүйцэтгэгч (тендерийн саналд орсон, зөвшөөрөгдсөн мэргэжлийн дэд гүйцэтгэгчээс бусад) болон саналд орсноос өөр компанийн ур чадварыг үнэлэхгүй болно. (ДБХАД-6.27).

Сонирхлоо илэрхийлж буй зөвлөхийн анхаарах зүйл бол ДБХАД-ийн гуравдугаар хэсгийн 3.14, 3.16, 3.17 бөгөөд уг заалт нь Дэлхийн банкны сонирхлын зөрчлөөс сэргийлэх бодлогын дагуу баталсан болно.

Зөвлөх нь нэг л санал ирүүлэх бөгөөд санал нь дан ганц компанийнх, эсхүл хамтарсан, түншлэлийнх байж болно. Хэрэв зөвлөх, эсхүл түүний хамтарсан түншлэлийн этгээд нь нэгээс олон санал ирүүлсэн эсвэл өөр саналд оролцсон бол бүх саналыг хүлээн авахгүй хасна.

(ДБХАД-3.20). Зөвлөх нь өөрийн ур чадварыг нэмэгдүүлж, хийх ажлын чанар, үр дүнг сайжруулах бусад компаниудтай хамтарсан түншлэлд орж болох бөгөөд энэ тохиолдолд хамтарсан, эсхүл дэд гүйцэтгэгч гэдгээ маш тодорхой саналдаа дурдах ёстой. Хамтарсан, түншилсэн тохиолдолд хэрэв сонгогдвол гэрээг бүхэлд нь хамтдаа хариуцна.

Зөвлөхийг Худалдан авах ажиллагааны дүрэмд тодорхойлсон суурь гэрээний зохицуулалт болон тус “Санал ирүүлэх хүсэлт”-д заасны дагуу сонгоно.

Бусад мэдээллийг доорх хаягаар 09:00 - 17:00 цагийн хооронд авч болно.

Сонирхлоо 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 17:00 цагаас өмнө ОҮИТБС-ын Ажлын албанд биеэр, шуудангаар, цахим шуудангийн аль нэгээр албан бичгээр ирүүлнэ үү.

Монголын ОҮИТБС-ын Ажлын алба Санхүү, захиргааны мэргэжилтэн А.Отгонтунгалаг; Зохицуулагч Ш.Цолмон;

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу 26, Сүхбаатарын гудамж 8-5, Пийс Бьюлдинг 205 тоот өрөө

Утас: +976-70110525

Цахим шуудан: [finance@eitimongolia.mn](mailto:finance@eitimongolia.mn); [secretariat@eitimongolia.mn](mailto:secretariat@eitimongolia.mn)

### 1. Танилцуулга

Монгол Улс Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)-ын талаарх иргэд, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх зорилго тавьсан. Энэхүү зорилгыг хамтдаа хэрэгжүүлэхээр ОУИТБС-д нэгдсэн орнууд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө ил тод, хариуцлагатай олборлолтын талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах, иргэдийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх зорилтуудыг хэрэгжүүлж эхэлж байна. Иймд олборлох үйлдвэрлэлийн мэдээлэл, харилцаа, сурталчилгааг идэвхжүүлэх замаар ОУИТБС-ын талаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, түүнчлэн 2022 оны баталгаажуулалт, 2019-2022 оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмж, Үндэсний зөвлөлөөс гаргасан санал, шийдвэрийг хэрэгжүүлэхээр Ажлын албаны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 11 дугаар зорилтын 11.1 дэх зорилтод харилцаа, мэдээллийн ажлыг чанартай гүйцэтгэх зорилгоор PR-ын зөвлөх үйлчилгээ авахаар тусгасан болно. Уул уурхай, газрын тос зэрэг олборлох салбарын засаглалыг хариуцлагатай, ил тод болгох зорилго бүхий олон улсын санаачилга ОУИТБС нь 2006 оноос хойш Монгол Улсад хэрэгжиж байгаа билээ. Өнөөг хүртэл хариуцлагатай компаниуд, шийдвэр гаргагчдын дэмжлэг, иргэний нийгмийн байгууллагуудын тууштай, идэвхтэй зүтгэлийн үр дүнд Монгол Улс ОУИТБС-ыг амжилттай хэрэгжүүлж буй орны тоонд багтаж буй.

Гэсэн хэдий ч 16 дахь жилийнхээ нэгтгэл тайланг гаргаж байгаа энэхүү санаачилгын талаар олон нийтийн дундах ойлголт, мэдлэг сул, олон жилийн турш цугласан өгөгдөл мэдээллийг олборлох салбарын засаглалыг сайжруулахад ашиглах чадавх орон нутаг, үндэсний хэмжээнд чамлалттай байна.

Энэхүү нөхцөл байдал нь ОУИТБС-ыг цаашид амжилттай хэрэгжүүлэхэд тулгарч буй сорилт болж буй бөгөөд Ажлын албаны Харилцааны шинэчилсэн стратегид энэхүү сорилтыг даван туулах төлөвлөгөөг тусгаад байгаа юм.

Нөгөө талаас, ОУИТБС-ыг өнөөг хүртэл тасралтгүй хэрэгжүүлэхэд донор байгууллагуудын дэмжлэг нэн их байсан билээ. ДНБ-ийнхээ дөрөвний нэгийг олборлох салбараас бүрдүүлж буй Монгол Улс цаашид ОУИТБС-ыг бие даан хэрэгжүүлэхийн тулд Эрдэс баялгийн ил тод байдлыг хангасан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага их бий. Үүнийг түүхэн өгөгдөл мэдээллийн тусламжтай олон нийт, тэр дундаа уул уурхай бүхий орон нутгийн иргэд, удирдлага, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчдад ойлгуулах ажлыг Ажлын албаны харилцааны стратегийн нэг чухал хэсэг болгон авч үзсэн билээ.

### 2. Ажлын зорилго:

Монголын ОУИТБС-ын харилцааны стратеги, оролцогч талуудын зураглалтын дагуу олон нийтийн сүлжээгээр ил тод, хариуцлагатай уул уурхайн талаар олон нийтийн ойлголт, хандлагыг сайжруулах, оролцогч талуудыг идэвхжүүлэх, нэгтгэл тайлангийн үр дүн, зөвлөмж, баталгаажуулалтын үр дүнг олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулна.

#### 2.1. Ажлын зорилтууд

- 2.1.1. Холбогдох 4 аймагт хэвлэл мэдээллийн бүтээлч ажлын тухай сургалт зохион байгуулах;
- 2.1.2. Ирүүлсэн бүтээлүүдээс шилдэгийг нь шалгаруулах үйл ажиллагаа зохион байгуулах;
- 2.1.3. Шалгарсан шилдэг бүтээлийг олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулах;
- 2.1.4. Улаанбаатар хотод сургалт зохион байгуулах;

### 3. Ажлын цар хүрээ

Зөвлөх үйлчилгээ нь Төв, Дорнод, Дундговь, Баянхонгор гэсэн зорилтот 4 аймагт хариуцлагатай уул уурхайн контент бэлтгэх чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах, хариуцлагатай, ил тод уул уурхайн тухай хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүн гаргахад оршино.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангаж, оролцогч талуудыг идэвхжүүлж, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх бүтээлч контентэд дараах шаардлага тавигдана.

- ОУИТБС-ын түүхэн өгөгдлийн ашиглалтыг дэмжих;
- Зорилтот бүлгийнхэнд өгөгдөл ашиглалтын ач холбогдлыг таниулах;
- Орон нутгийн иргэд, тэр дундаа уул уурхайн нөлөөлөл ихтэй орон нутгийн иргэд, малчдад ил тод байдлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх;
- Орон нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоонд тулгуурлан компаниудын ОУИТБС-ын тайлан гаргалтыг нэмэгдүүлэх;
- Нэгтгэл тайлангийн үр дүнд түшиглэн ОУИТБС-ын ач холбогдлын талаар олон нийт, бодлого боловсруулагч, шийдвэр гаргах түвшинд хэлэлцүүлэг өрнүүлэхүйц байх;
- Одоо байгаа эрх зүйн ач холбогдлыг зорилтот бүлэгт таниулан, ойлголт, хандлагыг сайжруулах;
- Уул уурхайн нөлөөлөл бүхий аймгийн иргэдэд орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний ач холбогдлыг таниулах, гэрээ байгуулах үйл явцад иргэдийн оролцоог хангахыг уриалах;

### 3.1. Даалгавар:

#### 1. Бэлтгэл хангах

- Сонгогдох PR мэдээллийн зөвлөх нь хийх ажлын төлөвлөгөө боловсруулах;
- Төлөвлөгөө боловсруулахдаа Ажлын албаны санал, зөвлөмжийг тооцон анхаарна.

#### 2. Хурал, уулзалт, сургалт зохион байгуулах

- Зорилтот 4 аймагт сургалт зохион байгуулна.
- Хэвлэл мэдээллийн төлөөлөгчдийн нэгдсэн уулзалт, сургалтыг зохион байгуулна.

#### 3. Урамшууллын кампанит ажил

- Шалгаруулалтын шаардлагуудыг боловсруулан, үнэлгээ хийж, хариуцлагатай, ил тод уул уурхайн тухай хэвлэл мэдээллийн шилдэг бүтээгдэхүүнийг шалгаруулна.
- Хэвлэл мэдээллийн шилдэг ажлыг шалгаруулах шүүгчдийн бүрэлдэхүүнийг сонгож, ажиллуулна.
- Шилдэг хариуцлагатай, ил тод уул уурхайн тухай хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүнийг шүүгчдийн хамт шалгаруулна.
- Хариуцлагатай, ил тод уул уурхайн тухай хэвлэл мэдээллийн шилдэг бүтээгдэхүүнийг холбогдох төвийн сувгуудаар түгээнэ.
- Хариуцлагатай, ил тод уул уурхайн тухай хэвлэл мэдээллийн шилдэг бүтээгдэхүүнийг холбогдох холбогдох аймгуудын сувгуудаар түгээнэ.

## 4. Хүргэлт ба тайлагнах

### 4.1. Хүргэх материал /Хүлээлгэн өгөх бүтээгдэхүүн/:

- Сургалтын хөтөлбөр, зардлын тооцоо, тайлан
- Хариуцлагатай, ил тод уул уурхайн тухай хэвлэл мэдээллийн шилдэг бүтээгдэхүүний тухай тайлан.

### 4.2. Гүйцэтгэсэн ажлын тайлан:

- Эхлэлийн тайлан – 2023 оны 10 дугаар сарын 10
- Явцын тайлан – 2023 оны 11 дүгээр сарын 10
- Эцсийн тайлан – 2023 оны 12 дугаар сарын 10

### 4.3 Тайлагнах:

1. Эхлэлийн тайланг орон нутагт тавигдах сургалын нэгдсэн төлөвлөгөөний биелэлтийг боловсруулан ОУИТБС-ын Ажлын албанд танилцуулна.
2. Явц эсвэл завсрын тайланг Зөвлөх нь орон нутгийн шилдэг хэвлэл мэдээллийн хамгийн багадаа 4 бүтээлч ажлыг хүлээн авч, Улаанбаатар хотод зохион байгуулах хурлын төлөвлөгөөг гаргаж, шүүгчдийн бүрэлдэхүүний танилцуулгыг ОУИТБС-ын Ажлын албанд танилцуулан, баталгаажуулсан байна.
3. Эцсийн тайланг холбогдох үйл ажиллагаа, сургалтууд дууссаны дараа ОУИТБС-ын Ажлын хэсгийн хуралдаанд танилцуулна. Эцсийн тайланг танилцуулахдаа ажлын даалгаварын 3.1-ээс 3.3-аар боловсруулалтыг хийж дуусгаж ОУИТБС-ын Ажлын алба баталгаажуулсан байна.

## **5. Хугацаа**

Хэрэгжүүлэх нийт хугацааг 3 сараас хэтрүүлэхгүй байх бөгөөд 2023 оны 10-р сард эхлүүлэхээр төлөвлөж байна.

## **6. Төлбөрийн хуваарь**

1. Анхны төлбөр нь нийт үнийн дүнгийн 30 хувь байх бөгөөд гэрээ байгуулсаны дараа буюу ажил гүйцэтгэх төлөвлөгөө гаргаж ажлын албанд танилцуулсаны дараа шилжүүлнэ.
2. Хоёр дахь төлбөр нь нийт үнийн дүнгийн 60 хувьтай тэнцэх бөгөөд ажлын явцын тайланг хүлээн авсны дараа шилжүүлнэ.
3. Эцсийн тайланг хүлээн авсны дараа 10 хувийн төлбөрийг шилжүүлнэ.

## **7. Ерөнхий шаардлага:**

1. Зөвлөх нь татварын өргүй байх. Үүнийг Татварын Ерөнхий Газарын тодорхойлолтоор баталгаажуулна.
2. Зөвлөх нь нийгмийн даатгалын өргүй байх. Нийгмийн Даатгалын Ерөнхий Газарын тодорхойлолтоор баталгаажуулна.
3. Зөвлөх нь худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ зөрчөөгүй байх. Үүнийг Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газрын тодорхойлолтоор баталгаажуулна.

Ерөнхий шаардлагад нийцээгүй зөвлөхийн саналыг үнэлгээнд оруулахгүй хасна.

## **8. Үнэлгээний шалгуур үзүүлэлт, оноо:**

Зөвлөхийг CQS (Зөвлөх мэргэшлийн сонгон шалгаруулалт) аргачлалын дагуу сонгох бөгөөд дараах шалгуурыг үнэлнэ.

1. Сүүлийн 3 жилийн хугацаанд төсөвт өртөг нь уг тендертэй дүйцэх, орон нутагт амжилттай хэрэгжиж буй олон улсын төслийн зорилтот, хэвлэл мэдээллийн кампанит ажлыг зохион байгуулсан туршлагатай байх. Энэ нь кампанит ажил, төслийн хэрэгжилтийг захиалсан байгууллагын ажил хүлээлцсэн актаар нотлогдоно. (Нийт оноо 50)
  - Сүүлийн 3 жилийн хугацаанд төсөвт өртөг нь уг тендертэй дүйцэх, орон нутагт амжилттай хэрэгжүүлсэн болон хэрэгжиж буй ажлын тоо 5 ба түүнээс дээш: 50 оноо
  - Сүүлийн 3 жилийн хугацаанд төсөвт өртөг нь уг тендертэй дүйцэх, орон нутагт амжилттай хэрэгжүүлсэн болон хэрэгжиж буй ажлын тоо 4: 40 оноо
  - Сүүлийн 3 жилийн хугацаанд төсөвт өртөг нь уг тендертэй дүйцэх, орон нутагт амжилттай хэрэгжүүлсэн болон хэрэгжиж буй ажлын тоо 3: 30 оноо
  - Сүүлийн 3 жилийн хугацаанд төсөвт өртөг нь уг тендертэй дүйцэх, орон нутагт амжилттай хэрэгжүүлсэн болон хэрэгжиж буй ажлын тоо 2: 20 оноо
  - Сүүлийн 3 жилийн хугацаанд төсөвт өртөг нь уг тендертэй дүйцэх, орон нутагт амжилттай хэрэгжүүлсэн болон хэрэгжиж буй ажлын тоо 1: 10 оноо

2. Зөвлөхийн ерөнхий туршлага (бизнесийн салбарт ажилласан жил, хэвлэл мэдээллийн салбарт ажилласан жил). (Нийт оноо 30)

- Зөвлөх нь хэвлэл мэдээллийн салбарт ажилласан жилийн тоо 6 ба түүнээс дээш: 30 оноо
- Зөвлөх нь хэвлэл мэдээллийн салбарт ажилласан жилийн тоо 5: 25 оноо
- Зөвлөх нь хэвлэл мэдээллийн салбарт ажилласан жилийн тоо 4: 20 оноо
- Зөвлөх нь хэвлэл мэдээллийн салбарт ажилласан жилийн тоо 3: 15 оноо
- Зөвлөх нь хэвлэл мэдээллийн салбарт ажилласан жилийн тоо 2: 10 оноо
- Зөвлөх нь хэвлэл мэдээллийн салбарт ажилласан жилийн тоо 1: 5 оноо

3. Ажиллах хүчний ур чадвар.

Зөвлөхийн орон тооны сургалтын болон удирдах ажилтны тоо. Ажиллах хүчний чадавхыг хүчин төгөлдөр хөдөлмөрийн гэрээгээр мөн нийгмийн даатгалын тодорхойлолтоор баталгаажуулна. (CV, диплом, туршлага зэрэг боловсон хүчний гол мэдээллийг үнэлэхгүй). Зөвхөн үндсэн ажилчдад хамаарна. (Нийт оноо 20)

- Зөвлөхийн орон тооны сургалтын болон удирдах ажилтны тоо 5 ба түүнээс дээш: 20 оноо
- Зөвлөхийн орон тооны сургалтын болон удирдах ажилтны тоо 4: 16 оноо
- Зөвлөхийн орон тооны сургалтын болон удирдах ажилтны тоо 3: 12 оноо
- Зөвлөхийн орон тооны сургалтын болон удирдах ажилтны тоо 2: 8 оноо
- Зөвлөхийн орон тооны сургалтын болон удирдах ажилтны тоо 1: 4 оноо

Зөвлөхийн авбал зохих доод оноо 70 бөгөөд үүнээс доош оноо авсан зөвлөхийн саналаас татгалзана.